

**“АМЖИЛТЫН ГАРАА-4 ” ОРОС ХЭЛНИЙ
ШАЛГАЛТЫН ЗӨВЛӨМЖ**

Суралцагчдын сурлагын амжилт чанарыг ахиулах, элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сэтгэл зүйн бэлтгэл хангах зорилгоор Нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын дунд “Амжилтын гараа-IV” шалгалт зохион байгуулагдаа.

Орос хэлний хичээлээр нийт 120 суралцагч шалгагдсан бөгөөд 5 сурагч материал дээрээ хувилбараа тэмдэглээгүй тул, нийт 115 сурагчийн материал уншигджээ.

Шалгалтын бүтэц: Нийт 100 оноо бүхий 60 даалгавартай.

- I. Грамматика – 20 онооны сонгох даалгавар
- II. Лексика – 30 онооны сонгох даалгавар
- III. Чтение – 28 оноо бүхий 14 даалгавар
- IV. Часть-2 харгалзуулах болон танин мэдэхүйн 22 онооны даалгавартайгаар шалгалтын сэдэв 4 хувилбартай боловсруулагдсан.

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийг үнэлгээний 8 түвшинд харуулбал:

Хүснэгт -1

ТҮВШИН	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ	НИЙТ ТОО
ҮIII	90-100	12
ҮII	80-89	21
ҮI	70-79	13
Ү	60-69	9
IV	50-59	12
III	40-49	23
II	30-39	14
I	0-29	11
	Вариант тэмдэглээгүй, уншигдаагүй / 0 үзүүлэлттэй /	5
	Нийт	120 сурагч
	Гүйцэтгэлийн дундаж	57.3 %

- VIII түвшинд 12 сурагч
- VII түвшинд 21 сурагч
- VI түвшинд 13 сурагч
- V түвшинд 9 сурагч
- IV түвшинд 12 сурагч
- III түвшинд 23 сурагч
- II түвшинд 14 сурагч
- I түвшинд 11 сурагч тус тус үнэлэгдсэн бөгөөд нийт сурагчдын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт 57.3 хувьтай байна.

- А хувилбарын хамгийн өндөр гүйцэтгэл нь 98%, хамгийн бага гүйцэтгэл нь 16%

- В хувилбарын хамгийн өндөр гүйцэтгэл нь 96%, хамгийн бага гүйцэтгэл 28%
- С хувилбарын хамгийн өндөр гүйцэтгэл 93%, хамгийн бага гүйцэтгэл 23%
- D хувилбарын хамгийн өндөр хувь нь 93%, хамгийн бага хувь нь 16% байгаа нь шалгалтын сэдвийн хувилбар хоорондын агуулга тохирсон байна гэж үзлээ.

Даалгаврууд:

№	Даалгаврын бүтэц	Өндөр хувьтай гүйцэтгэл	Бага хувьтай гүйцэтгэл
1	Грамматика	71.7%	40%
2	Лексика	64.2%	40%
3	Чтение	84.2%	50%
4	II хэсгийн даалгаврууд	67.8%	40%



Гүйцэтгэл багатай даалгаврууд, эдгээр даалгаврын гүйцэтгэл 14 - 30% байна. Үүнд:

- Тэмдэг нэрийн харьцуулсан зэрэг, харьцуулсан давуу зэргийн хэрэглээний даалгавар
 - Мне кажется немецкая овчарка ... из всех пород собак
 - ... мальчик из нашего двора был хорошим шахматистом
 \ умнее, самая умная, самый умный, умнейший\
- Харьяалахын тийн ялгалын хугацаа илэрхийлэх “ДО” угтварын хэрэглээ
 - Ребята вошли в класс ... звонка.
- тэмдэг нэр, нэр үгтэй зохицох
 - Мы встречали ... с большими букетами цветов.
 - Когда мы жили в Африке, я часто думал ...
 \ наши друзья, наших друзей, наши поездки, о наших поездках \
- Үгсийн сангийн даалгаварт тохирох зөв үгийг сонгоход \ үгийн утга мэдэхгүй, үгийн баялаг дутмаг\
 - Монголию нельзя представить без ... песни
 \протяжной, эстрадной, современной, эстрадной \
- Өгүүлбэрийг зөв дараалалд оруулах
 - \ в России, в США, приехал из Иркутска \
- Хүнд хүсэлтээ, талархаснаа илэрхийлэх боловсон зөв харьцааны үгсийн хэрэглээ
 - Будьте любезны...
 - Очень приятно...

Гүйцэтгэл 75-84 хувьтай, сурагчдын сайн хийсэн даалгаврууд :

- үйл үгийн ганц ба олон тооны хэрэглээ
- тэмдэг нэр нэр үгтэй зохицох \ эр, эм хүйс\
- нэр үг тийн ялгалаар хувирч үйл үгтэй зохицох
- нөхцөл заасан ХНӨ холбоосын хэрэглээ \ если\, что\бы ..\
- нэр үгийн олон тоог тэмдэг нэртэй зохицуулах \ книги какие? интересные\

- өгүүлбэрийн утгыг ойлгож утгаар нь зөв холбох

Даалгавар тус бүрийн гүйцэтгэл:

Бүрэлдэхүүн хэсэг	Даалгаврууд	Зөв хариултын тоо	Буруу хариултын тоо	
	1	Үйлдэх, харьяалахын т.я	75	45
	2	Харьяалах, заах, угтвар үгт т.я	68	52
	3	Өгөхийн т.я, угтвар үгт т.я	78	42
	4	1, 2-р цаглахуй	83	37
	5	Нийлмэл ирээдүй цаг	70	50
	6	Нийлмэл ирээдүй цаг	61	59
	7	Үйл үгийн өнгөрсөн цаг	55	65
	8	Үйл үгийн өнгөрсөн цаг	65	55
	9	Тэмдэг нэр, нэр үгийн зохицол	86	34
	10	Тийн ялгал, үйл үгийн чиглүүлэл	60	60
	11	Нийлмэл давуу зэрэг	49	71
	12	Тэмдэг нэр, нэр үгийн зохицол	84	36
	13	Үйл үгийн чиглүүлэл (говорить, ходить, передать, прийти)	70	50
	14	Үйл үгийн чиглүүлэл (думать, встречать, гулять)	65	55
	15	Үйл үгийн чиглүүлэл (сидеть, вспоминать, относиться)	58	62
	16	Холбоос үгийг утгаар нь сонгох (как, когда, если, чтобы)	68	52
	17	Холбоос үгийг утгаар нь сонгох (хотя, потому что, если бы, если)	59	61
	18	Холбоос үгийг утгаар нь сонгох (и, а, но, если ...)	68	52
	19	Угтвар үгийн хэрэглээ (в, к, о, по, у, на, от, до, ...)	63	57
	20	Угтвар үгийн хэрэглээ (под, между, по, за, до, к, в, с ...)	74	46
Лексика	21	Орон судлал (бэлгэ тэмдэг)	70	50
	22	Орон судлал (бэлгэ тэмдэг)	60	60
	23	Үгийн сан (үйл үгийн утгыг таних)	65	55
	24	Үгийн сан (нэр үгийн утгыг таних)	71	49
	25	Үгийн сан (нэр үгийн утгыг таних)	48	72
	26	Өгөгдсөн харилцан ярианы зөв хариултыг хувилбаруудаас сонгох	72	48
	27	Харилцан яриаг утга зүйн хувьд тохируулах	64	56
	28	Харилцан яриаг утга зүйн хувьд тохируулах	67	53
	29	Өгөгдсөн харилцан ярианы зөв хариултыг хувилбаруудаас сонгох	77	43
	30	Харилцан яриаг утга зүйн хувьд өгөгдлөөс сонгон тохируулах	60	60
	31	Тухайн нөхцөлд юу хийх вэ? (Хувилбаруудаас зөв хариултыг сонгох)	76	44
	32	Зарлалын утгыг ойлгох, хариулах	75	45
	33	Зарлалын утгыг ойлгох, өгөгдлөөс зөв хариултыг сонгох	61	59
	2.3	Өгөгдсөн үгсээс сонгон өгүүлбэрийг гүйцээх	61	59
Бүгд		4109	3091	

Нийт гүйцэтгэлийн хувьд суралцагчдын зөв хариултын тоо буруу хариултын тооноосоо 1018- аар илүү байна.

Хоёрдугаар хэсгийн даалгаврын танин мэдэхүйн түшний гүйцэтгэл

Энэ хэсэгт А,В,С,Д хувилбарууд бүгд 2 онооны 11 даалгавартай байлаа

№	хувилбар түм түвшин	А		В		С		D		нийт дундаж
		даалгавры н тоо	гүйцэлгэл дундаж	даалгавры н тоо	гүйцэлгэл дундаж	даалгавры н тоо	гүйцэлгэл дундаж	даалгавры н тоо	гүйцэлгэл дундаж	
1	сэргээн санах	3	43	2	51	2	50	1	66	52.5
2	ойлгох	2	38	3	44	2	67	3	60	52.3
3	хэрэглэх	4#	69	4	50	4	56	4	74	62.3
4	задлан шинж-х	2	31	2	40	3	46	3	70	46.8

Гүйцэтгэлийн дунджаас үзэхэд сурагчид сэргээн санах, ойлгох, хэрэглэх түшний даалгавруудыг сайн гүйцэтгэсэн байна. Энэ нь танин мэдэхүйн доод түшний даалгаврууд байсан бөгөөд цаашид задлан шинжлэх, танил бус нөхцөлд бүтээх, асуудал шийдвэрлэх гэх мэт танин мэдэхүйн дээд түшний чадварт суралцах нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖЛӨХ НЬ

1. Багш нар шалгалт эхлэхийн өмнө санамжийг танилцуулдаг ч сурагчдын хайнга байдал, шалгалтын материалаа дахин хянадаггүйгээс хувилбар тавихгүй явуулж байна. Үүнээс болж машинд хянагдахгүй байгааг анхааруулан хэлж өгөх
2. Өдөр тутам хэрэглэгддэг үг, холбоо үг, өгүүлбэр хэвшмэл хэллэг, оньсого, зүйр үгийн утгыг тайлбарлаж өгөх, хэрэглээ болгох
3. Олон улын түвшинчлэл, ТРКИ –ийн жишигт нийцүүлсэн дасгал, даалгавруудыг ажиллуулах, энгийн танил сэдвүүдээс гадна танин мэдэхүйн өргөн хүрээг хамарсан, шинжлэх ухаан, түүх, газарзүй, эдийн засаг, биологи зэрэг сэдвүүдтэй танил болгох
4. Орос хэл дээр сурагчдын нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон богино хэмжээний эх, хялбаршуулсан ном зохиолыг уншуулж тэмдэглэл хөтлүүлэх, яриулах, хэлэлцүүлэг хийх замаар унших ойлгох чадварыг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Т. САРАННЭМЭХ

/ГАДААД ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ,
СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН/

Э. БАЯНБАТ

/72-Р СУРГУУЛИЙН ОРОС ХЭЛНИЙ БАГШ/

Д. УРАНЧИМЭГ

/113-Р СУРГУУЛИЙН ОРОС ХЭЛНИЙ БАГШ/